

## ТӨРӨӨС КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО /2020-2027/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### 1.1. Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд тулгарч буй өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээний гол үр дүн:

Олон улсын байгууллага, зарим өндөр хөгжилтэй улс орнуудын компанийн нийгмийн хариуцлагын талаар баталсан бодлого, хөтөлбөрт туссан тодорхойлолтуудаас харахад Компанийн нийгмийн хариуцлагыг “*Бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, удирдлагын шийдвэр нь хүний эрх, хөдөлмөр эрхлэлт, хүрээлэн буй орчин нийгэмд сөрөг нөлөөгүй, ажиллагсад, хөрөнгө оруулагч, түншүүд болон хэрэглэгчдийн өмнө хүлээсэн үүргээ ил тод, ёс зүйтэй, шударгаар биелүүлж, хууль тогтоомж болон нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрдөх*” гэж нэгтгэн тодорхойлж болохоор байна.

Компанийн нийгмийн хариуцлагыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд түүний мөн чанар, ач холбогдлыг таниулахаас гадна албадлагын бус арга хэрэгслээр хэвшүүлэх нь илүү үр дүнд хүрдгийг ИБУИНВУ, ХБНГУ, Скандинавын зарим улс орнуудын жишээ<sup>2</sup>-нээс тус тус харж болно.

Компанийн нийгмийн хариуцлагыг сүүлийн жилүүдэд улс орнууд, олон улсын байгууллагууд илүү чухалчлан авч үзэж, түүнийг хэрэгжүүлэх заавар стандарт, дүрэм журмуудаа тогтмол шинэчлэн сайжруулсаар байна. Мөн Герман, Итали зэрэг улс орнууд компанийн нийгмийн хариуцлагын урт хугацааны бодлого, стратегийг батлан амжилттай хэрэгжүүлж байна.

Дээрх улс орнууд компанийн нийгмийн хариуцлагын бодлогоо тодорхойлохдоо эрх зүй, эдийн засаг, мэдээлэл, түншлэл эдгээрийн холимог гэсэн бодлогын хэрэгслүүдийг авч ашиглаж байна<sup>1</sup>. Энэ арга хэрэгслүүд нь компанийн нийгмийн хариуцлагын талаарх ойлголт, хэрэгжилтийг сурталчлах, чадавхыг бэхжүүлэх, мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах, нэгдсэн байдлаар тайлагнах тогтолцоог бүрдүүлэх, нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих, оролцогч талуудын түншлэл, манлайллыг бий болгох гэсэн хүрээг хамарч байна.

---

<sup>1</sup> Reinhard Steurer, Andre Martinuzzi, and Sharon Margula, “Public Policies on CSR in Europe: Themes, Instruments, and Regional Differences,” *Corporate Social Responsibility and Environmental Management*, 2012

Мөн олон улсын байгууллагууд болох Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын “Үндэстэн дамнасан корпорацийн аргачлал, зааварчилгаа”, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Үндэстэн дамнасан корпораци, нийгмийн бодлогын норм, зарчмын тухай гурван талт тунхаглал”, Олон улсын стандартын байгууллагын “Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх зөвлөмж - ISO 26000 стандарт”, Нэгдсэн үндэстний байгууллагын “Даяар тайлагнах санаачлаг”, “Даян Дэлхийн Гэрээ” Европын Комиссын “Компанийн нийгмийн хариуцлагын Европын хүрээ” зэрэг бодлогын баримт бичгийг тус тус гаргасныг олон улсын хэмжээнд мөрдөж байна.

Монгол улсын хувьд НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ”-нд анх нэгдэн орсноос хойш /2006-2011/ нийт 176 компани энэ гэрээнд нэгдэн орж байсан бол 2015 онд батлагдсан “Тогтвортой хөгжлийн зорилт”-д нийцүүлэн тайлан гаргах шалгуур өндөрсгөж, жил бүр татвар төлдөг болсон шалтгаанаар 2019 онд тус гэрээнд нэгдэн, тайлангаа хүргүүлж буй компанийн тоо 3 болон буурсан байна.

Үүнээс гадна “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д Монгол улс 2006 онд нэгдэн орж 2018 оны байдлаар нийт 1489 компани тайлан гаргаж байгаа бол Дэлхийн эдийн засгийн форумын “Авилгын эсрэг санаачилга”-д 160 гаруй компани нэгдсэн байна.

Мөн Олон улсын стандартын байгууллагаас баталсан Компанийн нийгмийн хариуцлагын ISO 26000:2010 стандартыг 2012 онд Үндэсний MNS 26000:2012 стандарт/зөвлөмж болгон баталж одоогоор 5 компани сайн дураар нэвтрүүлсэн байна. Гэвч эдгээрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар мэдээлэл хангалтгүй байна.

Компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /GTZ/, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Компанийн Засаглалын Хөгжлийн Төв, Oshmi групп, Зах зээл судлалын хүрээлэн зэрэг байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх байгууллагууд нь “Компанийн нийгмийн хариуцлагын талаарх монгол улсын төрийн бодлого, түүний хэрэгжилт”, “Монголын уул уурхайн салбар дахь нийгмийн хариуцлага”, “Компанийн нийгмийн хариуцлага ба тогтвортой хөгжлийн зорилтууд”, “ТОП-100 компанийн засаглал” зэрэг судалгааг хийсэн байна.

Дээрх “Монгол улсын ТОП-100 компанийн засаглал” судалгаанд<sup>2</sup> 58 компани хамрагдсанаас 29.3 хувь нь компанийн нийгмийн хариуцлагын бие даасан бодлоготой, 67 хувь тодорхой үйл ажиллагааг санхүүжүүлдэг, 63 хувь нь жил бүр дээрх үйл ажиллагаанд 50-аас дээш сая төгрөгийг төсөвлөдөг байна.

---

<sup>22</sup> Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөлийн хийсэн судалгаа, 2018

“Нөхцөл байдлын дүн шинжилгээ”<sup>3</sup>-ний хүрээнд цахим мэдээллээс авсан түүвэр судалгаанд хамрагдсан томоохон 20 компани нь сүүлийн 10 жилд нийгмийн эрүүл мэнд, боловсрол, бүтээн байгуулалт, сайн дурын үйлс зэрэг нийгмийн хариуцлагыг тасралтгүй хэрэгжүүлж ирсэн байна. Эдгээр ажлуудын 47% мод тарих, 22% байгаль орчны нөхөн сэргээх, 15% ан амьтан хамгаалахад чиглэсэн байна.

Уг судалгаанд хамрагдсан дунд төвшний 20 компанийн хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь тогтворгүй, илүү хандив тусламжид чиглэсэн хандлагатай байгаа бол жижиг 10 компанийн хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд бодитой үйл ажиллагаа явуулаагүй байна.

Үүнээс дүгнэхэд ашигтай ажиллаж буй томоохон аж ахуйн компаниуд нийгмийн хариуцлагаа илүү ухамсарлан хэрэгжүүлснээр компанийн нэр хүнд, өрсөлдөх чадвараа өсгөөд зогсохгүй, нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр, нөлөөлөл нь ч өндөр байна.

Монгол улсын хувьд Компанийн нийгмийн хариуцлагыг тусгайлан авч үзсэн төрийн бодлого, хууль тогтоомж одоогоор батлагдаагүй ч УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын зорилтын хүрээнд компанийн нийгмийн хариуцлагын асуудал тодорхой хэмжээнд тусгагдсан.

Мөн байгаль орчин, татвар, хөдөлмөр, худалдан авах ажиллагаа, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой хууль, тогтоомжуудад компанийн нийгмийн хариуцлагыг дэмжих, урамшуулах, хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтууд туссан хэдий ч эдгээр хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, хяналт, тайлагналын тогтолцоо сул, олон нийт болон бусад оролцогч талуудын хамтын ажиллагаа сул байна<sup>4</sup>.

Шалтгаан нь компанийн нийгмийн хариуцлагын нэгдсэн бодлого, стратеги батлагдаагүй, уг чиг үүргийг хариуцан ажиллах төрийн байгууллага байхгүй, хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хяналт сул зэрэг шалтгаануудыг дурдаж болохоор байна.

Нөгөө талаас бизнес эрхлэгчдийн хүрээнд нийгмийн хариуцлагын талаар нэгдсэн ойлголт бий болоогүй, мэдлэг, мэдээлэл, туршлага дутмаг, эдийн засгийн болон эдийн засгийн бус дэмжлэг, хөшүүрэг хангалтгүй, санхүүгийн чадавх сул шалтгаанууд голлон нөлөөлж байна гэж үзэж болохоор байна.

Иймд дээрх нөхцөл байдлын шинжилгээний гол үр дүн, Герман улсын компанийн нийгмийн хариуцлагын талаар батлан хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, олон улсын байгууллагаас гаргасан гэрээ, стандарт, зөвлөмжид

---

<sup>33</sup> Төрөөс компанийн нийгмийн хариуцлагын талаар баримтлах бодлого боловсруулахад шаардлагатай Нөхцөл байдлын дүн шинжилгээ, 2019

<sup>4</sup> Нөхцөл байдлын дүн шинжилгээ- “Хууль, эрх зүйн орчны дүгнэлт, зөвлөмж”, Хуудас 89

тулгуурлан, харьцуулан үзсэний үндсэн дээр компанийн нийгмийн хариуцлагыг монгол улсад хэрэгжүүлэхэд тулгарч буй хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж “Төрөөс компанийн нийгмийн хариуцлагын талаар баримтлах бодлого”-ыг боловсруулав.

Тус бодлогыг хэрэгжүүлснээр манай улсад компанийн нийгмийн хариуцлагын талаар нэгдсэн ойлголт бий болж, төр, хувийн хэвшил, олон нийтийн хамтын ажиллагаа илүү сайжран, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч компани, хувь хүний тоо нэмэгдэх, хөгжлийн урт, дунд хугацааны бодлогуудад туссан зорилтыг төр, хувийн хэвшил хамтран амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

## **1.2. Бодлого боловсруулах үндэслэл**

Монгол улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тушаалыг тус тус үндэслэн 8 жилийн хугацаатай “Төрөөс компанийн нийгмийн хариуцлагын талаар баримтлах бодлого”-ыг боловсруулсан.

## **1.3. Бодлогын хамрах хүрээ**

“Төрөөс компанийн нийгмийн хариуцлагын талаар баримтлах бодлого” /2020-2028/ нь дараах 5 үндсэн чиглэлийг хамарна. Үүнд:

1. Нэгдсэн ойлголтыг бий болгох, мэдлэг, мэдээлэл, сургалт, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулах;
2. Бодлого, үйл ажиллагааг уялдуулах, хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын статусыг тодорхой болгох;
3. Төрийн болон төрийн өмчит компанийн нийгмийн хариуцлага, ил тод байдал, тайлагналын тогтолцоог сайжруулах;
4. Нийгмийн хариуцлагатай компанийг бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх;
5. Дотоодын болон олон улсын гэрээ, стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

### **2.1. Бодлогын зорилго:**

Компанийн нийгмийн хариуцлагын нэгдсэн ойлголтыг нийгмийн бүх төвшинд бий болгож, сургалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулснаар ач холбогдол,

ойлголтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хувьд тогтвортой, нийгмийн зөв хандлагыг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг худалдан авалт, хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, урамшууллын бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, дотоодын болон олон улсын стандарт, зөвлөмжийг сайн дураар хэрэгжүүлэх компанийн тоог нэмэгдүүлж, бодлого, үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулан хэрэгжүүлэх төрийн байгууллагын чиг үүрэг, статусыг тодорхой болгох.

## **2.2. Бодлогын зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.**

2.2.1. Компанийн нийгмийн хариуцлагын талаарх нэгдсэн ойлголтыг нийгмийн бүх төвшинд бий болгож, мэдлэг, мэдээлэл олгох, боловсон хүчнийг бэлтгэж, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулна.

2.2.2. Компанийн нийгмийн хариуцлагын дотоодын болон олон улсын гэрээ, стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, тогтмол тайлан гаргах боломжийг бүрдүүлнэ.

2.2.3. Нийгмийн хариуцлагатай компанийг татвар, санхүү, худалдан авалт, хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, урамшууллын бусад бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.2.4. Төрийн болон төрийн өмчит компанийн нийгмийн хариуцлагын манлайлал, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангуулна.

2.2.5. Компанийн нийгмийн хариуцлагын бодлого, үйл ажиллагааг хөгжлийн бодлогын зорилт, үйл ажиллагаатай уялдуулах, хэрэгжилтийг хангах төрийн байгууллагын чиг үүрэг, статусыг тодорхой болгоно.

## **2.3. Бодлогыг хэрэгжүүлэх хугацаа, үе шат:**

Төрөөс баримтлах бодлогыг 2020-2027 он хүртэлх хугацаанд дараах хоёр үе шатаар хэрэгжүүлнэ. Үүнд:

### **Нэгдүгээр дүгээр үе шат: (2020-2023)**

- Нэгдсэн ойлголт бий болгох, мэдлэг, мэдээлэл олгох сургалт, зөвлөгөөн зохион байгуулах, бодлого, үйл ажиллагааг уялдуулах, хэрэгжилтийг хангах, чиг үүрэг, бүхий байгууллагын статусыг тодорхой болгох, Компанийн нийгмийн хариуцлагын бодлого үйл ажиллагааг хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны зорилт, үйл ажиллагаатай уялдуулах, үе;

### **Хоёдугаар дугаар үе шат: (2024-2027)**

- Дотоодын болон олон улсын гэрээ, стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагналын нэгдсэн тогтолцоог бий болгох, Нийгмийн хариуцлагатай компанийг худалдан авалт, хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, урамшууллын бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх үе;

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ.**

#### **БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**3.1. Компанийн нийгмийн хариуцлагын талаарх нэгдсэн ойлголтыг нийгмийн бүх төвшинд бий болгож, мэдлэг, мэдээлэл олгох, боловсон хүчнийг бэлтгэх, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулна.**

3.1.1. Компанийн нийгмийн хариуцлагын нэгдсэн тодорхойлолтыг олон улсад ашиглагдаж буй нэршил, тодорхойлолтууд болон өөрийн орны онцлог, нөхцөл байдал, иргэдийн үнэт зүйл, нийтлэг ойлголтод тулгуурлан холбогдох хууль тогтоомжуудад шинээр тусгаж тодорхойлох;

3.1.2. Компанийн нийгмийн хариуцлагын нэгдсэн ойлголт, мэдээллийг олон нийтэд сурталчлах, түгээх ажлыг улсын хэмжээнд тогтмол зохион байгуулах;

3.1.3. Их, дээд сургууль, коллежийн эдийн засаг, бизнесийн сургуулийн багш, оюутнууд болон бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтын модуль, гарын авлага боловсруулах, сургалт, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах;

3.1.4. Компанийн нийгмийн хариуцлагын бодлогын хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, санал, зөвлөмж боловсруулах зорилготой үндэсний чуулган, хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулах.

**3.2. Компанийн нийгмийн хариуцлагын бодлого, үйл ажиллагааг хөгжлийн бодлогын зорилт, үйл ажиллагаатай уялдуулах, хэрэгжилтийг хангах төрийн байгууллагын чиг үүрэг, статусыг тодорхой болгоно.**

3.2.1. Компанийн нийгмийн хариуцлагын бодлогын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах байгууллагын статус, чиг үүргийг тодорхой болгож, холбогдох хууль, тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж батлуулах;

3.2.2. Компанийн нийгмийн хариуцлагын тайлан, үнэлгээний аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн, хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулж, батлуулах, хэрэгжилт, ил тод байдлыг хангуулах, олон нийтэд сурталчлах;

**3.3. Төрийн болон төрийн өмчит компанийн нийгмийн хариуцлагын манлайллыг бий болгох, ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох.**

3.3.1. Компанийн нийгмийн хариуцлагын сайн туршлагыг амжилттай хэрэгжүүлж буй төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын манлайлал, үйл ажиллагаагаа дэмжих, урамшуулах, хүний нөөцийн чадавхийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.3.2. Нийгмийн хариуцлагын тайланг төрийн болон төрийн өмчит компаниуд тогтмол гаргах, ил тод байдлыг хангуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.3.3. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн нийгмийн хариуцлагын бодлого, үйл ажиллагааг хөгжлийн урт, дунд хугацааны бодлоготой уялдуулах, чиглүүлэх;

**3.4. Нийгмийн хариуцлагатай компанийг худалдан авалт, хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл бусад урамшууллын бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.**

3.4.1. Хөгжлийн урт хугацааны бодлого, ногоон хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн компанийн нийгмийн хариуцлагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг худалдан авалт, хөрөнгө оруулалт, татвар, санхүү, зээл, зээлийн батлан даалтын бодлогоор дэмжих, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.4.2. Компанийн нийгмийн хариуцлагыг төр, хувийн хэвшил, олон нийт, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор хамтран хэрэгжүүлэх санаачлагыг дэмжиж, санхүүгийн болон санхүүгийн бус хэлбэрээр дэмжлэг үзүүлэх.

**3.5. Компанийн нийгмийн хариуцлагын дотоодын болон олон улсын гэрээ, стандарт, хэлэлцээр, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, тогтмол тайлан гаргах, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлнэ.**

3.5.1. Компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр батлагдан гарсан дотоодын болон олон улсын гэрээ, стандарт, зөвлөмжийг сайн дураар хэрэгжүүлж, тайлан гаргадаг компанийн тоог нэмэгдүүлэх, тайлан гаргах, үнэлэх, олон нийтэд ил тод мэдээллэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

3.5.2. Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудаас компанийн нийгмийн хариуцлагын талаар батлан гаргасан зөвлөмж, стандарт, гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.5.2. Холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд Нийгмийн хариуцлагын чиглэлээр хүлээсэн үүрэг, хариуцлагын биелэлтийг хангуулах, олон нийтэд ил тод мэдээллэх, хариуцлага тооцох ажлыг холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

### **4.1. Бодлогыг хэрэгжүүлсэнээр гарах үр нөлөө.**

**Компанийн нийгмийн хариуцлагын нэгдсэн ойлголт, мэдлэг мэдээлэл бий болж, бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх нэгдсэн бүтэц, тогтолцоо бүрдэнэ:**

Компанийн нийгмийн хариуцлагын нэгдсэн ойлголт, мэдлэг, мэдээлэл олон нийтэд бий болж, бодлогыг хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоог бүрдүүлсэнээр хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, үйл ажиллагааг хувийн хэвшлийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулах, олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, гэрээ, стандарт, хэлэлцээний хэрэгжилтийг хангагдаж, хэрэглэгч, үйлчлүүлэгч, олон нийтийн зүгээс нийгмийн хариуцлагатай худалдан авалтыг дэмжих соёл, хандлага бий болно.

**Нийгмийн хариуцлагыг бодлогоор дэмжиж, урамшуулсанаар эдийн засаг, байгаль орчин, нийгмийн өмнө тулгамдаж буй асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэл, олон нийтийн хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэх боломж бүрдэнэ:**

Компаниуд нийгмийн хариуцлагын бодлого, үйл ажиллагаагаа тогтвортой хөгжлийн бодлого, ногоон хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого зорилтуудтай уялдуулж, тогтмол тайлан гаргах, төрийн худалдан авалт, татвар, санхүү, хөрөнгө оруулалт, зээл, зээлийн батлан даалт болон бусад бодлогоор дэмжигдэх боломжийг бүрдүүлсэнээр компаниуд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх сонирхол илүү нэмэгдэнэ.

Нийгмийн хариуцлагатай компанийн тоо нэмэгдсэнээр тухайн компанийн албан хаагчдын нийгмийн баталгаа сайжирч, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэж, үйлчилгээний чанар, соёлд дэвшил гарна.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлж, тогтмол тайлан гаргадаг



болсноор бусад аж ахуйн нэгж, байгууллагуудад зөв үлгэр дууриалал, манлайлалыг бий болгоно.

#### **4.2. Бодлогын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт:**

2019 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд бодлогын хэрэгжилтийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

***Шалгуур үзүүлэлтийн хүснэгтийг бодлогын зорилго, зорилт эцсийн байдлаар тодорхой болсоны дараа бичнэ. /Шалгуур үзүүлэлтийн талаар саналаа өгнө үү? /***

### **ТАВДУГААР БҮЛЭГ.**

#### **БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР**

Компанийн нийгмийн хариуцлагын талаар төрөөс баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 5.1. Улсын болон орон нутгийн төсөв;
- 5.2. Гадаадын зээл, тусламж;
- 5.3. Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төсөв;
- 5.4. Бусад эх үүсвэр;

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ.**

#### **БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

- 6.1 Компанийн нийгмийн хариуцлагын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь бодлогын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, уялдуулах, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, явцын тайланг жил бүрийн эхний хагас жилд багтаан холбогдох яам, агентлаг, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос авч нэгтгэн дүгнэж Засгийн газарт 2 жил тутам танилцуулах ажлыг зохион байгуулна.
- 6.2 Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөний талаар хөндлөнгийн үнэлгээний тайлан 3 жил тутам хийлгэж, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлнэ.

6.3 Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогыг хэрэгжүүлэх хугацааны нэгдүгээр үе шатны шалгуур үзүүлэлтийн зорилтод түвшний 30 хүртэл хувийг хангаагүй нь тогтоогдсон тохиолдолд бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах аль эсхүл хүчингүй болгох саналаа Монгол Улсын Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлнэ.